**ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2015 оны 06 сарын 10 өдөр Дугаар 09 Улаанбаатар

Л.БУЯНБАТЫГ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГААР СОНГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1, Компанийн дүрмийн 7.2.8 дахь заалт, Тахько (ХК) компанийн Төлөөлөн удирдах Зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Лутаагийн Буянбатыг Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлаас сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар сонгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ДАРГА Т.ДОРЖГОТОВ

ТАХЬКО (ХК) КОМПАНИ УЛААНБААТАР ХОТ. 2061007 ТТБ № 3884

# ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2015 оны 03 сарын 04 өдөр Дугаар 04 Улаанбаатар

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, Тахько (ХК) компанийн дүрмийн 7.2.2 дугээр зүйлийн "Б" хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 34 дүгээр тогтоол, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 10:00 цагаас компанийн байр (МА-III барилгын хурлын заал)-д хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцүүлэхээр тогтоосугай. Үүнд:
   - Компанийн 2014 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
   - Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох;
   - Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоож, дотоод ажлын зардлын төсвийг батлах.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд бэлтгэх, зохион байгуулах комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Комиссын даргад: | Л.Буянбат | ТУЗ-ийн дарга |
| Гишүүдэд: | Л.Энхнасан | Гүйцэтгэх захирал |
| | Ш.Мөнх-Очир | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга |

4 Хуралд бэлтгэх, зохион байгуулах комисст даалгах нь:
- Ээлжит хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд хүргэх зар мэдээг 2015 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн өдөр тутмын 2-оос доошгүй сонинд нийтлүүлж, радио, телевиз, компанийн болон Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан мэдээлэх;
- Энэхүү мэдээллийг 15 хоногийн дараа анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэх;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай мэдэгдлийг холбогдох бичиг баримтын хамт Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн бирж (ХК) компанид 2015 оны 03 дугаар сарын 05-ны дотор хүргүүлэх;
- Хурлаар хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөл, хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авах ажиллагааг үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий брокер, дилерийн компанитай гэрээ байгуулж, гэрээний дагуу зуучлуулан зохион байгуулах;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, тэдгээрийн танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төсөл, санал авах хуудсыг тэдний үйлчлүүлдэг брокер, диллерийн компанид 2015 оны 03 дугаар сарын 11-ний дотор хүргүүлэх;

- Хурлаар хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөл болон хувьцаа эзэмшигчдэд танилцуулах баримт бичгийг 2015 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөс 2015 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийг дуустал 09-13, 14-17 цагт компанийн байранд хувьцаа эзэмшигчдэд танилцуулж, саналын хуудсаар санал авах.

5 Хурал зарласан үед хувьцаа эзэмшигчдэд дор дурдсан баримт бичгийг танилцуулахыг хуралд бэлтгэх, зохион байгуулах комисст үүрэг болгосугай. Үүнд:
- Компанийн жилийн санхүүгийн тайлан;
- Санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудиторын дүгнэлт;
- Төлөлөөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн тухай танилцуулга;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшуулал, зардал;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдох бусад мэдээлэл;
- Хууль тогтоомжоор зөвшөөрсөн бусад мэдээлэл.

6 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын “Санал авах хуудас”-ны загварыг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.

7 Ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2015 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөр тогтоосугай.

8 Хуралд биеэр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийн санал авах хуудсыг хүлээж авах сүүлчийн хугацааг 2015 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 17:00 цагаар тогтоосугай.

9 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Л.Буянбатыг сонгосугай.

10 Хурлын тооллогын комиссын даргаар Д.Минжмаа, гишүүнээр Н.Гомбосүрэн, П.Сансартуяа нарыг томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ДАРГА Л.БУЯНБАТ

ЗАГВАР

*Тахько (ХК)компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 04 дүгээр тогтоолоор батлав.*

ТАХЬКО (ХК) КОМПАНИ УЛААНБААТАР ХОТ. 2061007 ТТБ № 3884

## ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС

**Хурал хуралдах хугацаа:** **Хурал эхлэх цаг:** **Дансны дугаар:** ..........................

**Хурал хуралдах газар:**

**Хувьцаа эзэмшигчийн** ........................................ **( эцэг, эхийн )** ................................................ **( нэр )**

**Регистрийн дугаар** ............................................ **Хувьцааны төрөл** .......................... **(энгийн, давуу)**

**Хувьцааны тоо** ........................

### *А. Ердийн аргаар санал авах асуудал*

| № | Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн товч утга | Зөвшөөрсөн (+) | Татгалзсан (+) | Түдгэлзсэн (+) |
|---|---|---|---|---|
| 1 | | | | |
| 2 | | | | |
| 3 | | | | |
| 4 | | | | |
| 5 | | | | |
| 6 | | | | |

### *Б. Кумулятив аргаар санал авах асуудал*

| № | Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох | Нэр дэвшигчид өгөх саналын тоо |
|---|---|---|
| | *Ердийн гишүүн* | |
| 1 | | |
| 2 | | |
| 3 | | |
| 4 | | |
| 5 | | |
| 6 | | |
| 7 | | |
| 8 | | |
| 9 | | |
| 10 | | |
| | *Хараат бус гишүүн* | |
| 1 | | |
| 2 | | |
| 3 | | |
| 4 | | |

**Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, нэр** ........................................... ( )

**Санал авах хуудсыг үйлдсэн** ............ **оны** .......... **дугаар сарын** ......... **-ны өдөр**

**Саналын хуудсыг хүчинтэйд тооцож тоолсон**
**Тооллогын комиссын дарга** ........................................ ( )

**Хүчингүйд тооцсон бол түүний шалтгаан** ..........................................................................................
..........................................................................................................................................................
..........................................................................................................................................................
..........................................................................................................................................................
..........................................................................................................................................................

*Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 34 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт*

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

| | |
|---|---|
| **Компанийн нэр:** | *Тахько (ХК) компани* |
| **Хаяг, утас:** | *Улаанбаатар 211238, Чингэлтэй дүүрэг,<br>5 дугаар хороо, Самбуугийн гудамж 18<br>Гар утас: 9911 3181, 9911 3624<br>Утас/факс: 325051* |
| **Хурал хуралдах огноо, цаг, газар:** | *2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 10:00 цагт компанийн байранд (МА-III барилгын хурлын зааланд)* |
| **Хурал хуралдуулах шийдвэр гаргасан огноо:** | *2015 оны 03 дугаар сарын 04* |
| **Олон нийтэд зарлах огноо:** | *2015 оны 03 дугаар сарын 06* |
| **Бүртгэх өдөр:** | *2015 оны 03 дугаар сарын 16* |
| **Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо:** | *2015 оны 03 дугаар сарын 11* |
| **Хүргүүлсэн огноо:** | |

**Ээлжит хурлын баримт бичгийн хуудасны тоо** ..... *хуудас*

**ЭЭЛЖИТ ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА** **(Л.БУЯНБАТ)**

ТАХЬКО (ХК) КОМПАНИ ... ТТБ № 3884 ... УЛААНБААТАР ХОТ ... 1007

**2015 оны 03 дугаар сарын 04-ний өдөр**

**ХҮЛЭЭН АВСАН БҮРТГЭЛИЙН МЭРГЭЖИЛТЭН** **(...............................)**

**2015 оны .... дугаар сарын ....-ны өдөр**

Хурлын зарын загвар

ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 10:00 цагаас компанийн байр (Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Самбуугийн гудамж 18, МА-III барилгын хурлын заал)-нд хуралдуулж, Тахько (ХК) компанийн 2014 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, тэдгээрийн цалин, урамшууллын хэмжээг тогтоож, зардал батлах зэрэг асуудлыг хэлэлцэнэ.

Хувьцаа эзэмшигчдийг 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд ажлын цагаар тус тусын үйлчлүүлдэг брокер, дилерийн компани болон компанийн байранд ирж хурлаар хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөлтэй танилцаж, саналаа өгөхийг урьж байна.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2015 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөр, хуралд биеэр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг хүлээж авах сүүлчийн хугацааг 2015 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 17:00 цагаар тус тус тогтоосон болно.

**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**
**Харилцах утас, факс: 99113181, 99113624, 325051**

**ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2015 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДРИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД БЭЛТГЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

| Д/д | Хийх ажлын утга | Хугацаа | Хаана |
|---|---|---|---|
| 1. | Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулах, холбогдох шийдвэрийг гаргах<br>• Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол<br>• Санал авах хуудасны загварыг батлах | 2015.03.04. | Компанийн байранд |
| 2. | ТУЗ-ийн хурлын материалыг Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн бирж /ХХ/ компанид хүргүүлэх<br>• Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол<br>• Санал авах саналын хуудасны загвар<br>• Хурал хуралдуулах тухай мэдэгдэл<br>• Хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр нийтэд мэдээлэх зарын загвар<br>• Хуралд бэлтгэх ажлын төлөвлөгөө | 2015.03.05. | СЗХ,<br>Хөрөнгийн Бирж |
| 3. | Хурал хуралдуулах тухай зар мэдээг өдөр тутмын 2-оос доошгүй сонинд нийтлүүлж, радио, телевиз болон Хөрөнгийн Биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлэх (хурал хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш 5 хоногийн дотор) | 2015.03.06. | Хөрөнгийн Бирж<br>Монголын Үнэн,<br>Зууны мэдээ,<br>ТВ-9 телевиз |
| 4. | Энэхүү зар мэдээг 15 хоногийн дараа анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэх | 2015.03.21. | Хөрөнгийн Бирж<br>Монголын Үнэн,<br>Зууны мэдээ,<br>ТВ-9 телевиз |
| 5. | Ээлжит хурлын баримт бичгийг танилцуулж, санал авах ажиллагааг зуучлан гүйцэтгэх гэрээг Брокер, дилерийн компанитай байгуулах | 2015.03.06. | "Таван Богд" БДК |
| 6. | Хурлаар хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөл, санал авах хуудас, бусад холбогдох материалыг БДК-д хүргүүлэх (зар мэдээг нийтэд анх хүргэсэн өдрөөс хойш 5 хоногийн дотор) | 2015.03.11. | "Таван Богд" БДК |
| 7. | Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй бүртгэл судалгааг 2015/03/16-ны өдрөөр тасалбар болгон авах | 2015.03.16. | ҮЦТТТХ Төв |
| 8. | Хурлын материалыг гаргасан шийдвэрийн хамт хурал хуралдсанаас хойш ажлын 3 өдрийн дотор хүргүүлэх | 2015.05.05. | СЗХ,<br>Хөрөнгийн Бирж |

**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**
**Харилцах утас, факс: 99113181, 99113624, 325051**

ТАХЬКО (ХК) КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

# ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ХҮРГЭХ ТАНИЛЦУУЛГА

Тахько (ХК) компани (хуучин нэрээр Оёдлын үйлдвэрийн нэгдэл) нь Монгол улсын Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын 1992 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 32 дугаар тогтоолоор хувьчлагдаж үүсгэн байгуулагдсанаас хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж, компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг жил бүр тогтоосон хугацаанд зарлан хуралдуулж, хурал хуралдуулах шийдвэр гаргах, хурлын зар мэдээг хүргэх ажиллагааг хууль тогтоомжид заасан нөхцөл, журам, шаардлагын дагуу хэрэгжүүлж хэвшүүлж ирсэн ба хувьцаа эзэмшигчдэд 1992, 1993, 1994, 1995, 1998, 1999, 2005, 2006, 2007, 2008, 2009, 2010, 2011, 2012, 2013 оны ногдол ашгийг зохих журмын дагуу хуваарилан олгосон бөгөөд 1993-2013 онуудад нийтдээ 531,135.0 мянган төгрөгийн ногдол ашиг олгоод байна.

Одоо тус компани нь үл хөдлөх эд хөрөнгийн түрээс, үйлчилгээ; гадаад дотоод худалдаа; хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулдаг, улсын төсөвт болон нийгмийн даатгал, татварын байгууллагад өр төлбөргүй болно.

Компанийн тухай хууль, компанийн дүрэм, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 34 дүгээр тогтоолоор баталсан "Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай" журмыг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 10:00 цагаас компанийн байр (Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Самбуугийн гудамж-18, МА-III барилгын хурлын заал)-нд хуралдуулахаар товлож, дор дурдсан асуудал хэлэлцүүлэхээр тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэсэн болно.Үүнд:

- Компанийн 2014 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, нарийн бичгийн даргын цалин, урамшууллын хэмжээг тогтоож, дотоод ажлын зардлын төсвийг батлах.

Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигч Та бүхэнд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төслийг үүгээр хүргүүлэн танилцуулж байна. Үүнд:

## Нэгдүгээр асуудал. Компанийн 2014 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт

Тахько (ХК) компанийн Төлөөлөн удирдах зөвлөл 2014 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дэвшүүлсэн зорилт, шийдвэрийг биелүүлж, бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, тайлангийн хугацаанд 14 удаа хуралдаж, 17 асуудал хэлэлцэж, 54 заалт бүхий 23 тогтоол шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан байна.

Төлөөлөн удирдах зөвлөл Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2014 оны ээлжит хурлыг Компанийн тухай хуульд заасан хугацаа, төрийн зохицуулах байгууллагаас баталсан журамд заасан шаардлагад нийцүүлэн зарлаж, хүчин төгөлдөр саналын эрхийн 85,56 хувийн ирцтэйгээр товлосон хугацаанд хуралдуулж, хурлаар хэлэлцсэн асуудлыг хуралд оролцогчдын дийлэнх олонхийн саналын эрхээр шийдвэрлэсэн байна.

Компанийн тухай хуульд заасан эрхийн дагуу Тахько (ХК) компанийн "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-д өөрчлөлт оруулах талаар 2014 оны 08 дугаар сарын 11-ний өдөр хувьцаа эзэмшигчдээс эчнээ санал хураалт явуулж, эчнээ санал хураалтад саналын эрхтэй 1,189,983 ширхэг энгийн хувьцаа эзэмшигчид оролцохоос саналын бүхий 642,631 ширхэг энгийн хувьцаа эзэмшигчид саналаа ирүүлж, нийт саналын эрхийн 54 хувь санал хураалтад оролцож, эчнээ санал хураалтаар санал авсан асуудлаар саналын эрхийн олонхоор шийдвэрлэсэн байна.

Компанийн тухай хууль, төрийн зохицуулах байгууллагаас тогтоосон журмын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн ба хараат бус гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар сонгож, хуулийн шаардлагыг хэрэгжүүлсний дээр дарга, нарийн бичгийн дарга, гишүүд 100 хувь компанийн засаглалын сургалтад хамрагдан ажиллаж ирэв.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын, Цалин урамшууллын болон Нэр дэвшүүлэх хороодыг ажиллуулж байна.

Компанийн санхүүгийн тайланг шалгаж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх аудитын компани, аудиторыг тус тус сонгон ажиллуулж байна.

Компанийн ногдол ашгийн бодлогын журмын дагуу 2013 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд олгох ногдол ашгийн хэмжээг 65,0 төгрөгөөр тогтоож, 1,189,983 ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг 630 хувьцаа эзэмшигчдэд 77,348,895 төгрөгийн ногдол ашиг хуваарилж, Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв компаниар зуучлуулан хувьцаа эзэмшигчдэд олгох ажлыг зохион байгуулж, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид тайлагнасан байна.

Төлөөлөн удирдах зөвлөл 2014 онд хууль тогтоомж, төрийн зохицуулах байгууллагаас гаргасан журам, заавар, засаглалын кодекс, үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагатай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлж ажилласнаар нээлттэй 329 хувьцаат компаниас Монголын хөрөнгийн биржийн шалгуур, онооны үзүүлэлтийг хангалттай биелүүлсэн компанийн нэг болсон байна.

Тахько (ХК) компанийн захиргаа 2014 онд (гүйцэтгэх удирдлага, зохион байгуулалтын нэгжийн албадууд) хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж, Компанийн дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж ажилласан болно.

Компанийн захиргаа тайлангийн хугацаанд удирдлага, захиргааны ба техник үйлчилгээний алба гэсэн зохион байгуулалтын бүтэцтэй, ажлын байрны 25 орон тоо бүхий бүрэлдэхүүнтэй ажил үүргээ гүйцэтгэж, Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулсан 2014 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөт зорилтоо биелүүлж ажиллав.

Тайлангийн хугацаанд үндсэн түрээслэгч Ньютел (ХХ) компанитай байгуулсан удаан хугацааны гэрээний хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан түрээсийн үйлчилгээний гэрээг шинэчлэн хийх ажлын хэсэг байгуулж, Мобиком компанитай МА-II барилгын талбайг 3 жилийн хугацаагаар түрээслүүлэх гэрээг хийж, МА-I барилгын 1,2 давхарын талбайг шинээр өөр бусад байгууллага, аж ахуйн нэгжид түрээслүүлэх зорилгоор Скайтел, Юнител (ХХ) компаниудын дунд сонгон шалгаруулалтыг явуулж, Скайтел (ХХ) компанитай түрээсийн үйлчилгээний гэрээг байгуулан компанийн үндсэн орлогын эх үүсвэрийг бүрдүүлж ажилласан байна.

Компанийн хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр МА-I барилгын дулааны болон сантехникийн системийн иж бүрэн засвар, угсралтын ажлыг хийж шинэчилсэн бөгөөд Ньютел (ХХ) компани нь МА-III барилгын түрээсийн гэрээгээ цуцалсантай холбогдуулан компанийн ашиг орлогыг нэмэгдүүлэх зорилгоор уг барилгыг цаашид бизнесийн зориулалтаар ашиглах, тухайлбал, хүүхэд залуучууд болон олон нийтийн соёл урлаг, боловсролын чиглэлээр олон төрлийн үйл ажиллагаа явуулах төв болгон өөрчлөн шинэчлэх ажлыг хийсэн байна. Энэхүү төслийг хэрэгжүүлэх зорилгоор МА-III барилгын иж бүрэн засварын ажлыг хийж гүйцэтгэн тус барилгын архитекторын зураг төслийн ажил, иж бүрэн цахилгаан, дулаан, сантехникийн угсралт, дотор тохижилт засварын ажил болон тус төвийн хэвийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмжийг худалдан авч иж бүрэн тохижуулсан.

Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, бизнесийн цар хүрээг нэмэгдүүлэх, компанийн цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох зорилгоор холбогдох зах зээлийн судалгааг хийж, компанийн хөгжлийн хэтийн төлөвийг боловсруулах зорилгоор "Horizon Partners LLC" компанитай хамтран "Хэтийн хөгжил EDUTAINMENT CENTER" төслийг боловсруулж, Францын "ARCHETYPE" компаниар уг төслийн зураг төсөл, интерьер дизайныг хийлгэхээр тохиролцоод байна. Уг компаниар үл хөдлөх хөрөнгийн ирээдүйн хөгжлийн архитекторын иж бүрэн зураг төслийг хийлгэж, компанийн хөгжлийн хэтийн төлөвийг тодорхойлох юм.

Тайлангийн хугацаанд компанийн үндсэн хөрөнгийн өөрчлөлт, элэгдэл хорогдлын шимтгэл, сэлбэг, аж ахуйн барилга байгууламж, хангамж, шатах тослох материал, кассын тооцоонд хяналт тавьж, анхан шатны баримтын бүрдүүлэлтийг бүрэн хийлгэж, тайлан бүртгэлийг зохих журмын дагуу хөтөлж ажилласанаар ямар нэгэн зөрчил дутагдал гараагүй байна. Бэлэн мөнгөний зарцуулалт, түүнд тавих хяналт сайжирч, хэвшсэн болно.

Компани нь хэрэглэсэн цахилгаан, дулаан, ус, газрын төлбөр зэрэг тогтмол зардлын төлбөрийг тогтоосон хугацаанд нь барагдуулж, алданги торгууль хүлээгээгүй, харилцагч байгууллагаас авах төлбөрүүдийг тухай бүрт нь нэхэмжлэн авч орлогыг бүрдүүлж байсан байна.

Компанийн санхүүгийн тайлан тэнцэл, аж ахуйн нэгжийн орлогын, хувь хүний орлогын, үл хөдлөх эд хөрөнгийн, авто тээвэр өөрөө явах хэрэгсэлийн, нэмэгдсэн өртгийн албан татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан тооцоог тогтоосон хугацаанд нь гаргаж, хуульд заасан хугацаанд харилцдаг санхүү, татвар, нийгмийн даатгалын байгууллагад тушааж, тайлангийн хугацаанд улсын төсөвт 20,137,099 төгрөгийн татвар, нийгмийн даатгалд 58,394,407 төгрөгийн шимтгэл төлж, төсөвт төлөх төлбөрийн 98.2 хувийг тайлангийн жилд барагдуулжээ.

Компани нь 2014 онд 1,935,128.4 мянган төгрөгийн орлоготой, 1,479,357.1 мянган төгрөгийн зарлагатай, 394,115.38 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан, 2013 оны гүйцэтгэлтэй харьцуулахад компанийн орлого 570,608.4 мянган төгрөгөөр, зардал 428,945.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, балансын ашиг 136,765.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Компани 2014 оны санхүүгийн тайлан тэнцлээр 2,298,026.85 мянган төгрөгийн хөрөнгө, үүнээс 1,593,026.28 мянган төгрөгийн үл хөдлөх хөрөнгөтэй болсон байна .

Компанийн тайлант хугацааны жилийн санхүүгийн үйл ажиллагаанд Мэдээлэл-Аудит компаниар хөндлөнгийн аудит хийлгүүлж, дүгнэлт гаргуулав.

Санхүүгийн тайлангийн хураангуй ба эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг дор дурдсан байдлаар танилцуулж байна. Үүнд:

**2014 оны жилийн тайлан тэнцлийн хураангуй үзүүлэлт**

*(төгрөгөөр)*

| Балансын зүйл | Үлдэгдэл | | Балансын зүйл | Үлдэгдэл | |
|---|---|---|---|---|---|
| | Эхний | Эцсийн | | Эхний | Эцсийн |
| А. Хөрөнгө | x | x | Б. Өр төлбөр эзэмшигчийн өмч | x | x |
| I.Эргэлтийн хөрөнгийн дүн | 1,088,836,076.16 | 959,447,543.77 | I. Өр төлбөрийн дүн | 22,539,328.53 | 34,893,699.06 |
| Мөнгөн хөрөнгө | 592,016,719.46 | 539,491,825.54 | Богино хугацаатай өр төлбөр | 22,539,328.53 | 34,893,699.06 |
| Богино хугацаатай хөрөнгө оруулалт | | | Урт хугацаатай өр төлбөр | | |
| Авлага | 453,531,869.07 | 364,370,220.91 | Үүнээс банкны хугацаа хэтэрсэн өр | | |
| Бараа материал | 42,100,037.63 | 50,842,507.32 | II. Өмчийн дүн | | |
| Үндсэн ба туслах материал | | | Төрийн | | |
| Урьдчилж төлсөн тооцоо | 1,187,450.00 | 4,742,990.00 | Хувийн | | |
| Бусад | | | III. Хувьцаа дүн | 199,917,144.0 | 199,917,144.0 |
| II. Биет хөрөнгийн дүн | 772,531,190.13 | 1,248,575,252.17 | Энгийн хувьцааны тоо, ширхэг | 1,189,983 | 1,189,983 |
| Барилга байгууламж | 1,197,729,870.98 | 1,593,026,286.43 | Нэрлэсэн үнэ | 168 | 168 |
| Газар | | | Давуу эрхтэй хувьцааны тоо, ширхэг | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Машин тоног төхөөрөмж | 18,478,102.73 | 77,381,651.82 | Нэрлэсэн үнэ | | |
| Тавилга, эд хогшил | 145,445,161.30 | 195,830,551.48 | Халаасны хувьцааны дүн | | |
| Бусад, тээврийн хэрэгсэл | 235,641,930.00 | 261,063,687.00 | | | |
| Хуримтлагдсан элэгдэл | 824,763,874.88 | 878,726,924.56 | IV. Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг | 387,604,403.3 | 387,604,403.3 |
| III. Биет бус хөрөнгийн дүн | 1,600,967.89 | 2,003,136.14 | V. Хуримтлагдсан ашиг | 1,340,908,278.35 | 1,675,611,605.62 |
| | | | Үүнээс:Тайлант үеийн ашиг | 281,547,268.83 | 394,115,386.58 |
| IV. Урт хугацаатай хөрөнгө оруулалт | 88,000,920.00 | 88,000,920.00 | VI. Эзэмшигчийн өмчийн дүн | 1,928,429,825.65 | 2,263,133,152.92 |
| Нийт хөрөнгийн дүн | 1,950,969,154.18 | 2,298,026,851.98 | VII.Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн | 1,950,969,154.18 | 2,298,026,851.98 |

**Нэгж хувьцаанд хуваарилсан ногдол ашиг (төгрөгөөр)**

| Он | 1992 | 1993 | 1994 1995 | 1998 1999 | 2005 | 2006 | 2007 | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Төг | 8.55 | 2.41 | 5.48 | 28.60 | 16.25 | 18.12 | 36.0 | 45.00 | 56.00 | 56.00 | 56.0 | 56.0 | 65.00 |

**Эдийн засгийн үндсэн үзүүлэлт**

*(Мянган төгрөгөөр)*

| Үзүүлэлт | 2011 | 2012 | 2013 | 2014 |
|---|---|---|---|---|
| 1. Цэвэр борлуулалт | 997,621.5 | 930,659.2 | 1,364,520.0 | 1,935,128.4 |
| 2. Борлуулсан бараа, бүтээгдэхүүний өртөг | | | | 4,897.9 |
| 3. Үйл ажиллагааны зардал | 714,394.3 | 651,855.7 | 1,050,412.1 | 1,479,357.1 |
| 4. Ашиг | 283,227.2 | 278,803.5 | 314,107.9 | 450,873.4 |
| 5. Хувьцааны арилжааны дундаж ханш (төгрөгөөр) | 4,291.36 | 5,772.04 | 7,324.10 | 10,055.60 |
| 6. Хувьцааны дансны үнэ (төгрөгөөр) | 1,287.60 | 1,439.95 | 1,620.55 | 1,901.82 |
| 7. Хувь нийлүүлэгчдийн тоо | 636 | 626 | 623 | 624 |
| 8. Хувьцааны төвлөрлийн хувь | 84.29 | 79.25 | 83.93 | 83.93 |

Төлөөлөн удирдах зөвлөл Компанийн тухай хууль, компанийн ногдол ашгийн бодлогын журмыг үндэслэн өмнөх онд нэгж хувьцаанд хувиарласан ногдол ашгийн хэмжээг нэмэгдүүлж 2014 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээг 82 төгрөгөөр тогтоож, нийт энгийн 1,189,983 ширхэг хувьцаанд 97,578,606 төгрөг хуваарилах шийдвэр гаргаж, энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдэд мэдээлж, 2015 оны 05 дугаар сарын 01-ний дотор Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвөөр зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар шийдвэрлээд байгааг мэдээлж байна.

Тахько (ХК) болон Ньютел (ХХ) компанийн хооронд байгуулсан 10 жилийн хугацаатай түрээсийн гэрээний хугацаа нь 2014 онд дуусгавар болж байгаатай холбогдуулан Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн 2014 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлаар Тахько (ХК) компанийн эзэмшлийн үл хөдлөх хөрөнгө болох МА-I, МА-II, МА-III, U-I барилгыг шинээр түрээслэх түрээсийн үйлчилгээний гэрээ байгуулах их хэмжээний хэлцэл хийх асуудлыг хэлэлцэж баталснаар МА-I, МА-II, U-I барилгыг Ньюком, Мобиком, Ньютел (ХХ) компаниудтай түрээсийн гэрээг шинэчлэн байгуулах их хэмжээний хэлцэл хийгдсэн болно.

Тахько (ХК) компанийн гүйцэтгэх удирдлага, албадууд, нийт ажиллагсад 2014 оны үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлж, Төлөөлөн удирдах зөвлөлийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж ажилласан байна.

2014 онд санхүү, эдийн засгийн орчин, бараа үйлчилгээний үнэ, инфляцийн түвшин зэрэг аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд шууд нөлөөлдөг нөхцөл нь сайнгүй байсан боловч Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага идэвх зүтгэлтэй ажиллаж компанийн санхүү, эдийн засгийн гол гол үзүүлэлт дээшилсэн байна.

Компанийн 2014 оны жилийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланг Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцээд компанийн гүйцэтгэх удирдлага, албадууд, нийт ажиллагсад 2014 оны зорилтот төлөвлөгөөгөө бүрэн хэрэгжүүлж, компани, хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж ажилласан гэж дүгнэж байна.

Компанийн 2014 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах саналыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оруулж байна.

## Хоёрдугаар асуудал. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1-д заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигч Л.Буянбат, Л.Энхнасан, Ж.Чимэдцэрэн нар 2015 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас сонгогдох Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Л.Буянбат, Л.Энхнасан, Ш.Мөнх-Очир, Б.Батхуяг, Т.Доржготов, Д.Минжмаа, Ж.Чимэдцэрэн, Г.Ганзул, Г.Оюунгэрэл нарын, хараат бус гишүүнээр С.Итгэл, Б.Бямбасүрэн, Б.Сийлэгмаа нарын нэрийг дэвшүүлэх саналыг Компанийн тухай хуулийн 66.1-д заасан хугацаанд буюу 2015 оны 02 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороонд бичгээр ирүүлсэн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хороо 2015 оны 03 дугаар сарын 02-ны өдөр хуралдаж, Компанийн тухай хуулийн 81 дугаар зүйлийн 81.5.3-т заасны дагуу Л.Буянбат, Л.Энхнасан, Ш.Мөнх-Очир, Б.Батхуяг, Т.Доржготов, Д.Минжмаа, Ж.Чимэдцэрэн, Г.Ганзул, Г.Оюунгэрэл нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгох нэрсийн жагсаалтад, С.Итгэл, Б.Бямбасүрэн, Б.Сийлэгмаа нарыг хараат бус гишүүнээр сонгох нэрсийн жагсаалтад тус тус бүртгэн авч, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нэрийг нь дэвшүүлэх тухай шийдвэрийг гаргасан болно.

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4-д зааснаар Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн ба хараат бус гишүүнээр сонгох хүмүүст тус тусад нь кумулятив аргаар саналаа өгөхийг хүсье.

## Гуравдугаар асуудал. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоож, зардал батлах тухай

Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, нарийн бичгийн даргын цалин, урамшууллын хэмжээг хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэж байхаар тогтоосон билээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын сарын цалинг 4,500,000 төгрөгөөр, зөвлөлийн ердийн гишүүний сарын цалинг 912,000 төгрөгөөр, зөвлөлийн хараат бус гишүүний сарын цалинг 1,080,000 төгрөгөөр, нарийн бичгийн даргын сарын цалинг 1,800,000 төгрөгөөр, тэдэнд жилд нэг удаа олгох урамшууллын дээд хэмжээг компанийн 2015 оны жилийн орлогын 2.5 хүртэл хувиар тус тус тогтоож, Төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод ажлын жилийн зардлыг 9,150,000 төгрөгөөр батлах санал оруулж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга нарын цалин, урамшууллын хэмжээ, Төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод ажлын жилийн зардлын хэмжээг санал болгон оруулж байгаа төслөөр баталж өгөхийг хүсч байна.

## КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Компанийн хувьцаа эзэмшигч Та энэ удаагийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөлтэй танилцаж, хавсаргаж хүргүүлсэн саналын хуудсаар саналаа өгөхийг хүсье.

Хурлын бүртгэх өдрийг 2015 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөр тогтоосон тул энэ өдрөөр бүртгэгдсэн хувьцаа эзэмшигч хуралд оролцох эрхтэй болно.

Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төслийн талаар лавлах, дэлгэрэнгүй мэдээлэл авах бол 99113181, 325051 утас, факс, цахим хаягаар эсвэл 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл хугацаанд ажлын цагаар компанийн байранд ирж танилцаж болно.

Хуралд биеэр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийн саналын хуудас хүлээж авах сүүлчийн хугацааг 2015 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 17:00 цагаар тогтоосон болно.

Хувьцаа эзэмшигч Таныг 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 10:00 цагаас Тахько (ХК) компанийн байр (Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Самбуугийн гудамж-18)-нд хуралдуулахаар товлосон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирж оролцохыг урьж байна.

**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**

Харилцах утас, факс, цахим хаяг

99113181, 325051, munkhochir_sh@yahoo.com

# ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙГ СОНГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д зааснаар 2014 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дараа жилийн хувьцаа эзэмшигчдийн хурал хийх өдрөөр дуусгавар болдог билээ.

Компанийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтын дагуу хувьцаа эзэмшигч Л.Буянбат, Л.Энхнасан, Ж.Чимэдцэрэн нар 2015 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас сонгогдох Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Л.Буянбат, Л.Энхнасан, Ш.Мөнх-Очир, Б.Батхуяг, Т.Доржготов, Д.Минжмаа, Ж.Чимэдцэрэн, Г.Ганзул, Г.Оюунгэрэл нарын, хараат бус гишүүнээр С.Итгэл, Б.Бямбасүрэн, Б.Сийлэгмаа нарын нэрийг дэвшүүлэх саналыг Компанийн тухай хуулийн 66.1-д заасан хугацаанд буюу 2015 оны 02 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороонд бичгээр ирүүлсэн байна.

Компанийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1-д заасан хугацаанд нэр дэвшүүлсэн өөр санал бусад хувьцаа эзэмшигчдээс ирээгүй байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хороо нь 2015 оны 03 дугаар сарын 02-ны өдөр хуралдаж, Компанийн тухай хуулийн 81 дүгаар зүйлийн 81.5.3-т заасны дагуу Л.Буянбат, Л.Энхнасан, Ш.Мөнх-Очир, Б.Батхуяг, Т.Доржготов, Д.Минжмаа, Ж.Чимэдцэрэн, Г.Ганзул, Г.Оюунгэрэл нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгох нэрсийн жагсаалтад, С.Итгэл, Б.Бямбасүрэн, Б.Сийлэгмаа нарыг хараат бус гишүүнээр сонгох нэрсийн жагсаалтад тус тус бүртгэн авч, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нэрийг нь дэвшүүлэх тухай шийдвэрийг гаргасан болно.

Нэр дэвшүүлэх хорооноос Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгуулахаар хувьцаа эзэмшигчдийн хуралд нэрийг нь дэвшүүлсэн хүмүүсийн товч мэдээлэл

| № | Овог, Нэр | Төрсөн он, нас, хүйс | Боловсрол, Мэргэжил | Ажилласан хугацаа | Одоогийн эрхэлж байгаа ажил, албан тушаал |
|---|---|---|---|---|---|
| | | | ***Ердийн гишүүнээр*** | | |
| 1 | Лутаагийн Буянбат | 1974/41 эрэгтэй | Магистр, Олон улсын харилцаа, улс төр, эдийн засагч | 9 | Тахько (ХК) компанийн ТУЗ-ийн дарга |
| 2 | Лутаагийн Энхнасан | 1972/43 эмэгтэй | Магистр, менежмент | 17 | Тахько (ХК) компанийн Гүйцэтгэх захирал |
| 3 | Шаравын Мөнх-Очир | 1964/51 эрэгтэй | Дээд, Инженер, улс төр судлаач | 28 | Тахько (ХК) компанийн ТУЗ-ийн н/б дарга |
| 4 | Батболдын Батхуяг | 1974/41 эрэгтэй | Дээд, Эрх зүйч | 16 | Х.О.Т. (ББСБ)-ийн захирал |
| 5 | Түдэвийн Доржготов | 1951/64 эрэгтэй | Дээд Инженер, эдийн засагч | 39 | Татекс (ХХ) компанийн захирал |
| 6 | Даваадашийн Минжмаа | 1968/47 эмэгтэй | Дээд Философич, эрх зүйч | 24 | МӨХ-ны өмгөөлөгч |
| 7 | Жамбаагийн Чимэдцэрэн | 1958/57 эмэгтэй | Дээд Эдийн засагч | 29 | Тахь-Электроникс (ХХ) компанийн захирал |
| 8 | Ганхуягийн Ганзул | 1980/35 эрэгтэй | Бакалавр Бизнесийн удирдлага | 11 | Тахь-Электроникс (ХХ) компанид менежер |
| 9 | Ганхуягийн Оюунгэрэл | 1985/30 эмэгтэй | Магистр Бизнесийн удирдлага | 7 | Горжис (ХХ) компанийн захирал |

***Хараат бус гишүүнээр***

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | Батнасангийн Бямбасүрэн | 1952/63 эмэгтэй | Дээд мэргэшсэн ня-бо | 42 | Пантер-мидланд Аудит (ХХ) компанийн Гүйцэтгэх захирал |
| 2 | Сахъяагийн Итгэл | 1967/48 эрэгтэй | Дээд Инженер | 22 | Ач Холдинг (ХХ) компанийн захирал |
| 4 | Базаррагчаагийн Сийлэгмаа | 1985/30 эмэгтэй | Бакалавр Бизнесийн удирдлага | 11 | Аглут (ХХ) компанид санхүүгийн менежер |

